

**БҮГД НАЙРАМДАХ УЗБЕКИСТАН УЛСЫН НИЙСЛЭЛ ТАШКЕНТ ХОТОД МОНГОЛ
УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ НЭЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 01 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат уг төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, Төв Азид оршдог, 35 сая хүн амтай тус улстай гадаад харилцаа, худалдаагаа өргөжүүлэх боломжтой гээд, манай улсын Элчин сайдын яам тус улсад үйл ажиллагаагаа явуулах Элчин сайдын яамны байраа түрээслэх эсэхийг тодруулан асууж, боломжтой бол байраа худалдаж авах нь зүйтэй тухай, Бүгд Найрамдах Индонез Улс, Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсад байгуулсан элчин сайдын яамдыг татан буулгасан шалтгааны талаар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Бүгд Найрамдах Узбекистан Улс нь Төв Азид оршдог, байрлал сайтай, цаашид хөгжих боломжтой улс учраас тус улстай гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх, хөрөнгө оруулалтыг татахад анхаарах, Элчин сайдын яамны байраа худалдаж авах нь зүйтэй бөгөөд хаана, ямар байршилд үл хөдлөх хөрөнгө худалдаж авах талаар сайн тооцоолох, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд шинээр Элчин сайдын яам байгуулахад аж ахуйн талын хүндрэл, бэрхшээл ихтэй байдаг тул энэ тал дээр туршлагатай хүмүүсийг тус улсад томилоход анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Элчин сайдын яам нээн ажиллуулахыг дэмжиж байгаагаа илэрхийлээд, Төв Азидаа хамгийн том эдийн засагтай, 80 тэрбум долларын дотоодын нийт бүтээгдэхүүнтэй, алт, зэс, газрын хий, нефть олборлож боловсруулдаг улс тул манай улсын Засгийн газраас баримтлаж байгаа эдийн засгаа солонгоруулах хөтөлбөрт ашигтай бөгөөд цаашид хөдөө аж ахуй, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох, шууд нислэг, аялал жуулчлалыг нэмэгдүүлэх талаар Гадаад харилцааны болон холбогдох яамд анхаарч ажиллах нь зүйтэй гэсэн болно.

Мөн Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан Гадаад харилцааны яамны зүгээс Улсын Их Хурлын гишүүдийн хэлж буй саналуудыг анхааралдаа авч, ажил хэрэг болгох, Турк-Азербайжан-Казахстан-Монгол гэсэн дунд коридор, Турк-Азербайжан-Казахстан-Пакистан-Зүүн Өмнөд Ази гэсэн хоёр дахь коридор, Дундад Ази руу чиглэсэн Узбекистан-Киргиз-Эстони-Армени гэсэн чиглэлүүд дээр манай улсын

худалдааны бүс байж болох гарцыг судлах, Элчин сайдын яамны үйл ажиллагаа өргөжих үед орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн саналуудыг гаргалаа.

Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.ЭНХ-АМГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ...-ний ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

**Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод
Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай**

Дипломат албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулахаар тогтоосугай.

Гарын үсэг